



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/12-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.Open.audit.mn
Архангай аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141
Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860
Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Аудитор Н.Энхчимэг
Утас: 7033-3019
Цахим хаяг: EnkhchimegN@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024. 02. 23 № 50
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
Д.ТУЛГА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

Аймгийн Засаг даргын 2018 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн А/485 дугаар захирамжаар ШШГГазрын нэр өөрчлөгдсөнтэй холбоотой байгууллагын эзэмшил газрын хаяг, байршил, хугацаа талбайн хэмжээг төрийн үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгожээ. 2019 онд Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр 712 метр квадрат талбай бүхий тус газрыг байгууллагын эзэмшлийн биет бус хөрөнгөнд 7130000 төгрөгөөр үнэлэн бүртгэсэн байна. Улмаар аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны "Аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 13 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтад тус газрын зориулалтыг "төрийн захиргааны байгууллагын" зориулалтаар баталсныг аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн А/100 дугаар захирамжаар 5-8 давхар нийтийн орон сууц, 2023 оны 05 сарын 09-ны өдрийн А/273 дугаар захирамжаар үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон өөрчлүүлж 45 айлын орон сууц бариулсан байна.

Энэ нь МУЗГ-ын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дахь заалт "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гаргасан шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүрд Барилга, хот байгуулалтын яам,

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай урьдчилан зөвшилцөж, орон нутгийн өмчид болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан шийдвэрт өөрчлөлт оруулахдаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай, МУЗГ-ын 2020 оны 10 дугаар тогтоолын 7 дахь заалт "Төрийн болон орон нутгийн өмчид, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн доорх газар эзэмших, ашиглах эрхийг иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр олгосныг цуцлах...цаашид төрийн болон орон нутгийн өмчид хуулийн этгээдэд эзэмшүүлсэн газраас хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэнд эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байх, барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай" гэсэн заалтууд, аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны 13 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй байх бөгөөд аудитын оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 57 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 42 үндсэн зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас 95 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------|--|------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 49,806,825.38 | 49,443,367.36 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 218,098.86 | 955,592.86 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 218,098.86 | 955,592.86 |
| 31210 | Төгрөг | 218,098.86 | 955,592.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 218,098.86 | 955,592.86 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 49,588,726.52 | 48,487,774.50 |
| 35100 | Түүхий эд материал | 23,509,461.90 | 24,701,586.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 21,655,941.00 | 23,525,446.00 |
| 35130 | Эм боох материал | 1,853,520.90 | 1,176,140.00 |
| 35400 | Хангамжийн материал | 26,079,264.62 | 23,786,188.50 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,008,797.00 | 4,137,397.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 16,086,073.90 | 18,282,423.90 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 220,000.00 | 220,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 118,000.00 | 0.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 910,000.00 | 210,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,736,393.72 | 936,367.60 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,023,808,614.57 | 963,664,702.71 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,023,808,614.57 | 963,664,702.71 |
| 39200 | Биет хөрөнгө | 927,810,614.63 | 868,292,702.81 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 992,993,980.00 | 992,993,980.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -170,316,973.92 | -199,491,746.04 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 106,983,333.00 | 71,983,333.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -86,163,888.56 | -60,330,555.12 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 132,698,702.02 | 133,286,702.02 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -72,723,226.96 | -90,142,987.73 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 42,192,839.00 | 42,192,839.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -23,958,266.67 | -28,237,070.72 |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 867,750.00 | 867,750.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -263,633.28 | -329,541.60 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 95,997,999.94 | 95,371,999.90 |
| 39301 | Програм хангамж | 6,417,692.31 | 6,417,692.31 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -3,269,692.37 | -3,895,692.41 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 92,850,000.00 | 92,850,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,073,615,439.95 | 1,013,108,070.07 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 218,098.86 | 955,592.86 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 218,098.86 | 955,592.86 |
| 41300 | Өглөг | 218,098.86 | 955,592.86 |
| 41360 | Бусад өглөг | 218,098.86 | 955,592.86 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 218,098.86 | 955,592.86 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,073,397,341.09 | 1,012,152,477.21 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,073,397,341.09 | 1,012,152,477.21 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 204,847,946.70 | 204,847,946.70 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 204,847,946.70 | 204,847,946.70 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 734,996,396.72 | 673,751,532.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 767,289,200.33 | 734,996,396.72 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -32,292,803.61 | -61,244,863.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 133,552,997.67 | 133,552,997.67 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,073,615,439.95 | 1,013,108,070.07 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------|---|----------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 697,297,360.53 | 1,041,719,065.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 33,449,760.53 | 5,017,765.80 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 33,449,760.53 | 5,017,765.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,294,997.00 | 15,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 50,000.00 | 15,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,244,997.00 | 0.00 |

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|----------------|------------------|
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 26,162,506.92 | 0.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 5,992,256.61 | 5,002,765.80 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 663,847,600.00 | 1,036,701,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 659,347,600.00 | 1,028,701,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 659,347,600.00 | 1,028,701,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,500,000.00 | 8,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | 6,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,500,000.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 729,590,164.14 | 1,102,963,929.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 729,590,164.14 | 1,102,963,929.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 728,398,860.58 | 1,007,523,329.68 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 485,516,962.06 | 758,934,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 317,167,545.34 | 454,932,242.83 |
| 210102 | Нэмэгдэл | 165,301,360.72 | 254,552,612.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 25,200,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,048,056.00 | 24,250,044.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,732,034.69 | 16,685,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,732,034.69 | 16,685,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 87,930,199.69 | 91,574,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,605,097.69 | 16,320,784.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,976,763.00 | 65,976,768.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,348,339.00 | 9,277,148.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,669,544.48 | 15,878,575.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,803,515.00 | 1,595,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,497,000.00 | 10,745,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,143,390.00 | 2,002,729.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,750,467.66 | 1,534,445.60 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,475,171.82 | 0.00 |
| 2105 | Нормативт зардал | 32,542,003.55 | 30,901,042.82 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 779,038.40 | 1,536,491.70 |
| 210502 | Хоол, хүнс | 28,099,479.35 | 28,536,340.32 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,663,485.80 | 828,210.80 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,918,360.00 | 15,944,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,496,360.00 | 1,824,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 211,800.00 | 211,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,210,200.00 | 13,909,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 240,000.00 | 1,054,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 240,000.00 | 1,054,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,212,300.00 | 8,332,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,883,200.00 | 2,392,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 375,900.00 | 300,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 68,700.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 687,900.00 | 5,154,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 196,600.00 | 419,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 71,637,456.11 | 68,216,411.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 819,000.00 | 4,160,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,780,540.00 | 3,324,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 68,037,916.11 | 60,731,911.86 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,191,303.56 | 95,440,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,020,600.00 | 95,425,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 93,730,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,020,600.00 | 1,695,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 170,703.56 | 15,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 170,703.56 | 15,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | -32,292,803.61 | -61,244,863.88 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | -32,292,803.61 | -61,244,863.88 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-----|--|----------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 668,972,400.00 | 1,043,650,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,124,800.00 | 6,949,500.00 |

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|---------|---|----------------|------------------|
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,124,800.00 | 6,949,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,124,800.00 | 6,949,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,124,800.00 | 6,949,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 663,847,600.00 | 1,036,701,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 659,347,600.00 | 1,028,701,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 659,347,600.00 | 1,028,701,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,500,000.00 | 8,000,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,500,000.00 | 6,500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 1,500,000.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 660,773,301.14 | 1,042,325,306.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 660,773,301.14 | 1,042,325,306.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 659,581,997.58 | 946,884,706.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 485,516,962.06 | 758,934,900.00 |
| 210101 | Үндсэн цалин | 317,167,545.34 | 454,932,242.83 |
| 210102 | Нэмэгдэл | 165,301,360.72 | 254,552,612.97 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 25,200,000.00 |
| 210104 | Урамшуулал | 3,048,056.00 | 24,250,044.20 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,732,034.69 | 16,685,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,732,034.69 | 16,685,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 87,930,199.69 | 91,574,700.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,605,097.69 | 15,530,784.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,976,763.00 | 65,976,768.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 11,348,339.00 | 10,067,148.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 18,096,300.00 | 15,773,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,784,910.00 | 1,615,675.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,615,000.00 | 10,627,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,143,390.00 | 2,002,729.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,553,000.00 | 1,527,895.60 |
| 2105 | Нормативт зардал | 33,199,600.00 | 25,602,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 854,700.00 | 854,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 32,344,900.00 | 24,747,300.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 13,198,360.00 | 15,244,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,776,360.00 | 2,412,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 211,800.00 | 211,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,210,200.00 | 12,621,000.00 |
| 2107 | Томилот, зочны зардал | 240,000.00 | 1,054,500.00 |
| 210702 | Дотоод албан томилот | 240,000.00 | 1,054,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,069,001.14 | 14,529,506.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,739,901.14 | 8,589,906.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 375,900.00 | 300,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 68,700.00 | 66,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 687,900.00 | 5,154,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 196,600.00 | 419,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,599,540.00 | 7,484,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 819,000.00 | 4,160,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,780,540.00 | 3,324,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,191,303.56 | 95,440,600.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,020,600.00 | 95,425,600.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 93,730,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,020,600.00 | 1,695,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 170,703.56 | 15,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 170,703.56 | 15,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 8,199,098.86 | 1,325,494.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 7,981,000.00 | 588,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 7,981,000.00 | 588,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 7,981,000.00 | 588,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,981,000.00 | 588,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -7,981,000.00 | -588,000.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 218,098.86 | 737,494.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 218,098.86 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 218,098.86 | 955,592.86 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 767,289,200.33 | 1,105,690,144.70 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 767,289,200.33 | 1,105,690,144.70 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -32,292,803.61 | -32,292,803.61 |
| 4 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 734,996,396.72 | 1,073,397,341.09 |
| 5 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 734,996,396.72 | 1,073,397,341.09 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 734,996,396.72 | 1,073,397,341.09 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -61,244,863.88 | -61,244,863.88 |
| 8 | 2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл | 204,847,946.70 | 133,552,997.67 | 673,751,532.84 | 1,012,152,477.21 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--------|--|------------------|------------------|----------------|------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,028,701,300.00 | 1,028,701,300.00 | 0.00 | 100% |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,028,701,300.00 | 1,028,701,300.00 | 0.00 | 100% |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 933,775,700.00 | 933,775,700.00 | 0.00 | 100% |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 758,934,900.00 | 758,934,900.00 | 0.00 | 100% |
| 210101 | Үндсэн цалин | 475,000,200.00 | 454,932,242.83 | 20,067,957.17 | 96% |
| 210102 | Нэмэгдэл | 226,856,300.00 | 254,552,612.97 | -27,696,312.97 | 112% |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,310,000.00 | 25,200,000.00 | 1,110,000.00 | 96% |
| 210104 | Урамшуулал | 30,768,400.00 | 24,250,044.20 | 6,518,355.80 | 79% |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16,685,900.00 | 16,685,900.00 | 0.00 | 100% |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,685,900.00 | 16,685,900.00 | 0.00 | 100% |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 91,574,700.00 | 91,574,700.00 | 0.00 | 100% |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,805,000.00 | 15,530,784.00 | -725,784.00 | 105% |
| 210302 | Түлш, халаалт | 65,976,800.00 | 65,976,768.00 | 32.00 | 100% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,792,900.00 | 10,067,148.00 | 725,752.00 | 93% |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,097,900.00 | 13,097,900.00 | 0.00 | 100% |
| 210401 | Бичиг хэрэг | 917,000.00 | 939,675.00 | -22,675.00 | 102% |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,627,600.00 | 8,627,600.00 | 0.00 | 100% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,987,800.00 | 2,002,729.40 | -14,929.40 | 101% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,565,500.00 | 1,527,895.60 | 37,604.40 | 98% |
| 2105 | Нормативт зардал | 25,602,000.00 | 25,602,000.00 | 0.00 | 100% |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 854,700.00 | 854,700.00 | 0.00 | 100% |
| 210502 | Хоол, хүнс | 24,747,300.00 | 24,747,300.00 | 0.00 | 100% |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,332,800.00 | 14,332,800.00 | 0.00 | 100% |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,000,000.00 | 3,000,000.00 | 0.00 | 100% |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 211,800.00 | 211,800.00 | 0.00 | 100% |
| 210604 | Урсгал засвар | 11,121,000.00 | 11,121,000.00 | 0.00 | 100% |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 1,054,500.00 | 1,054,500.00 | 0.00 | 100% |
| 210702 | Дотоод албан томиллолт | 1,054,500.00 | 1,054,500.00 | 0.00 | 100% |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,332,500.00 | 8,332,500.00 | 0.00 | 100% |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,392,900.00 | 2,392,900.00 | 0.00 | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100% |

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|--------|---|------------------|------------------|------------|------|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 66,000.00 | 0.00 | 100% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,154,500.00 | 5,154,500.00 | 0.00 | 100% |
| 210807 | Газрын төлбөр | 419,100.00 | 419,100.00 | 0.00 | 100% |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,160,500.00 | 4,160,500.00 | 0.00 | 100% |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,160,500.00 | 4,160,500.00 | 0.00 | 100% |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94,925,600.00 | 94,925,600.00 | 0.00 | 100% |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 94,925,600.00 | 94,925,600.00 | 0.00 | 100% |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 93,730,600.00 | 93,730,600.00 | 0.00 | 100% |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,195,000.00 | 1,195,000.00 | 0.00 | 100% |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,028,701,300.00 | 1,028,716,300.00 | -15,000.00 | 100% |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,028,701,300.00 | 1,028,701,300.00 | 0.00 | 100% |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,028,701,300.00 | 1,028,701,300.00 | 0.00 | 100% |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 71 | 69 | 2.00 | 97% |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0.00 | 100% |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0.00 | 100% |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 35 | 34 | 1.00 | 97% |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100% |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 32 | 31 | 1.00 | 97% |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | 0.00 | 100% |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 35 | 34 | 1.00 | 97% |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 35 | 34 | 1.00 | 97% |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---------|--|--------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 6,934,500.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,934,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,934,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,934,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,934,500.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,212,006.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 6,212,006.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,197,006.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6,197,006.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,197,006.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 15,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 15,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 722,494.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 722,494.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 218,098.86 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 955,592.86 |
| 100 | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | -15,000.00 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Монгол Улсын газрын 2013 оны 38, 2020 оны 10 дугаар тогтоолын холбогдох заалтуудыг зөрчиж байгууллагын эзэмшилд бүртгэлтэй төрийн өмчийн 712 м.кв газрын зориулалтыг өөрчлөн үйлчилгээний зориулалттай орон сууц бариулсан зөрчил илэрсэнд холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах албан шаардлагыг эрх бүхий байгууллагуудад хүргүүллээ.

Байгууллагын эзэмшил дэх төрийн өмчийн газрыг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй зориулалтыг өөрчлүүлэн орон сууц бариулсан нь шинж чанарын хувьд бусдад давуу байдал бий болгосон байж болзошгүй зөрчил тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.1. Албан шаардлага

5.1.1. Аймгийн ИТХ-ын 2021 оны 13 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр тус байгууллагад эзэмшүүлсэн 712 м.кв талбай бүхий төрийн захиргааны байгууллагын зориулалттай газрын зориулалтыг аймгийн Засаг даргын 2023 оны А/273 захирамжаар үйлчилгээний төвтэй орон сууцны барилгын зориулалт болгож өөрчилж тус газар дээр 45 айлын орон сууцны барилга барьж ашиглалтад оруулсан байна.

Энэ нь МУЗГ-ын 2013 оны 38 дугаар тогтоолын 6 дахь заалт “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гаргасан шийдвэрт өөрчлөлт оруулах тухай бүрд Барилга, хот байгуулалтын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай урьдчилан зөвшилцөж, орон нутгийн өмчид болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх, ашиглуулах талаар гарсан шийдвэрт өөрчлөлт оруулахдаа аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг үндэслэж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай”, мөн 2020 оны 10 дугаар тогтоолын 7 дахь заалт “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эзэмшилд байгаа барилга байгууламжийн доорх газар эзэмших, ашиглах эрхийг иргэн, хувийн хэвшлийн хуулийн этгээдийн нэр дээр олгосныг цуцлах...цаашид төрийн болон орон нутгийн өмчид хуулийн этгээдэд эзэмшүүлсэн газраас хувийн хэвшлийн хуулийн этгээд, иргэд эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахгүй байх, барилга барих, эхлүүлэх зөвшөөрөл олгохгүй байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, бусдад давуу байдал олгосон байж болзошгүй тул ШШГЕГ-ын аудитад анхааран үзэж, холбогдох хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүллээ.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт болон аймгийн Засаг даргад тогтоол зөрчиж буруутай шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Аймгийн ИТХ-ын 2021 оны 13 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр тус байгууллагад эзэмшүүлсэн 712 м.кв талбай бүхий төрийн захиргааны байгууллагын зориулалттай газрын зориулалтыг аймгийн Засаг даргын 2023 оны А/273 захирамжаар үйлчилгээний төвтэй орон сууцны барилгын зориулалт болгож өөрчилж тус газар дээр 45 айлын орон сууцны барилга барьж ашиглалтад оруулсан байна. | 2 | | | | 2 | | - | - | | | | |
| Нийт дүн | | | | | 2 | | | | | | | |